

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Шинжлэх ухаан технологийн сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2020/22/СТА-ЗГТС

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2020 он	Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Д.Энхдалай Утас: 261885 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn Аудитор: С.Отгонхорлоо Утас: 261740 Цахим хаяг: otgonkhorloos@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.9. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	8
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	12
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	12
2.12. Шилэн дансны мэдээлэл	12
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	12
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	12
3. Менежментийн захидал	14
4.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	18
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	19
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	20
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	21
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	22
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	24
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	26

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ШУТС	Шинжлэх ухаан, технологийн сан
БСШУСС	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд
ЗГТС	Засгийн газрын тусгай сан



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН
САНГИЙН ЗАХИРАЛ М.ТУНГАЛАГ
ТАНАА

2020. 03. 25 № 01/937
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Шинжлэх ухаан технологийн сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Шинжлэх ухаан технологийн сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Шинжлэх ухаан технологийн сангийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



О.ТЭНГИС

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Шинжлэх ухаан технологийн сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Шинжлэх ухаан технологийн сангийн захирал М.Тунгалаг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн өөрийн үйл ажиллагааны орлого, зардал, авлага, өглөг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, тайлагнал, бүртгэлээр тавих дотоод хяналтыг боловсронгуй болгох, зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Шинжлэх ухаан технологийн сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шинжлэх ухаан технологийн сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 3 дугаар сарын 06-аас 2020 оны 3 дугаар сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын аудитор С.Отгонхорлоо гүйцэтгэв.

Шинжлэх ухаан технологийн сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 2/43 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе

шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Шинжлэх ухаан технологийн сангийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлийг онолын суурь судалгаа гүйцэтгэх, шинжлэх ухаан, технологийн болон инновацийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, эрдэм шинжилгээний ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэхэд эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүжилт олгох, зарцуулсан хөрөнгийн ашиглалтад хяналт тавих, нэгтгэн тайлагнах” гэж тодорхойлсон.

Шинжлэх ухаан технологийн сангийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Тухайн жилд Засгийн газрын захиалгаар хэрэгжүүлэх шинжлэх ухаан, технологийн болон иновацийн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд улсын төсвөөс олгох хөрөнгийн хэмжээг төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх;
- Шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр батлагдсан төслийн санхүүжүүлж, олгосон хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих, санхүүгийн тайлан тэнцлийг гаргуулан авч дүн шинжилгээ хийх, илэрсэн зөрчлийг арилгуулах;
- Эрдэм шинжилгээний ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэхэд зориулан эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр санхүүжилт хийх, хяналт тавих, үр дүнг тооцох, олгосон хөрөнгийг эргүүлэн төлүүлэх арга хэмжээ авах;
- Төслийн захиалагч, гүйцэтгэгч байгууллагатай төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх гэрээ байгуулах, гүйцэтгэлд хяналт тавих, хэрэгжиж дууссан төслийн бүртгэл хөтлөх;
- Төслийн хэрэгжилтийн явц, санхүүжилтийн талаарх мэдээллийг захиалагчтай хамтран хагас жил тутамд гаргах, дүнг шинжлэх ухаан технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх, нийтэд мэдээлэх;

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль 2019 он;
- Шинжлэх ухаан технологийн сангийн дүрэм, 2019 оны Загийн газрын 50 дугаар тогтоол;
- Шинжлэх ухаан, технологийн болон инновацийн төслийн саналд үнэлгээ өгч дүгнэлт гаргах аргачлал, 2018 оны БСШУСС-ын А/696 тушаал;
- Инновацийн төсөлд грант олгох, хэрэгжүүлэх гэрээ 2019 оны БСШУСС-ын А/123 тушаал;

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Шинжлэх ухаан технологийн сангийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу

шинэчлэгдсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулаагүй нь санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх үр дагавартай байна.

Шинжлэх ухаан технологийн сангийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Шинжлэх ухаан технологийн сангийн бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 10 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 10 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн нийт зардлын 2.0 хувиар сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг Шинжлэх ухаан технологийн сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 20,913.2 сая төгрөгийн 2.0 хувь буюу 418.3 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд шинжлэх ухааны хүрээлэн, төвүүд 11, төрийн өмчит аж ахуйн нэгж 1, тусгай сан 1, нийт 13 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс аудитад бүрэн хамрагдсан.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагууд түүвэрт 4, санал дүгнэлт гаргасан 9, үүнээс “Зөрчилгүй” 7, “Хязгаарлалттай” 2 /Ургамал хамгаалал эрдэм шинжилгээний хүрээлэн, Мал эмнэлгийн хүрээлэн/, дүгнэлт өгсөн байна.

Шинжлэх ухаан технологийн сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 715.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 355.3 сая төгрөгийн 7 алдааг аудитын явцад залруулж, 2.6 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 6.7 сая төгрөгийн 1 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 351.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 7 зөвлөмжийг хүргүүллээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд авлагыг 5.0 сая, урьдчилгааг 31.0 сая төгрөгөөр дутуу, бараа материалыг 2.5 сая, тайлант хугацааны элэгдлийг дутуу тооцооноос үндсэн хөрөнгийг хөрөнгийг 5.0 сая төгрөгөөр илүү, өр төлбөрийг 1.3 сая төгрөгөөр илүү, урьдчилж орсон орлогыг 28.3 сая төгрөгөөр дутуу нэгтгэсэн;
- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд санхүүжилтийн орлогыг 28.3 сая төгрөгөөр илүү, бусад орлогыг 0.1 сая төгрөгөөр дутуу, дээд шатны төсөв захирагчаас хуваарилсан орлогыг 109.5 сая төгрөгөөр дутуу, дээрх дүнгээр төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого илүү, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлыг 28.3 сая төгрөгөөр илүү, төвлөрүүлэх шилжүүлгийн зардлыг 5.0 сая төгрөгөөр илүү, тайлант үеийн зардлыг 1.5 сая төгрөгөөр дутуу нэгтгэсэн;
- Нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланд 1.5 сая төгрөгөөр тайлант үеийн үр дүн дутуу нэгтгэсэн;

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

1. Ажилчдын ээлжийн амралтыг олгохдоо унаа хоолны нөхөн олговрыг амралтын дунджаас хасаж тооцоолоогүй 2.6 сая төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.2-т "Ээлжийн амралтын олговрыг ажилтны тухайн ажлын жилийн дундаж цалин хөлсний хэмжээгээр тогтооно"; Төсвийн тухай хуулийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Унаа хоолны нөхөн олговрыг амралтын дунджаас хасаж тооцох, холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөх төлбөрийн акт тогтоох;

2. Нийгмийн даатгалын тайлангаар 6.7 сая төгрөгийн илүү төлөлт үүссэн, авлага үүсгэж бүртгэлд тусгаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах, барагдуулах албан шаардлага хүргүүлэх;

Төвлөрүүлсэн захирагчид 1,228.1 сая төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 6 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Шинжлэх ухаан технологийн сангийн 2019 оны санхүүгийн тайланд нэгтгэгддэг харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2,272.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1,695.6 сая төгрөгийн 13 алдааг аудитын явцад залруулж, 45.1 сая төгрөгийн 7 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 62.1 сая төгрөгийн 5 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 469.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 31 зөвлөмжийг өгсөн байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн залруулга

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд нийт 1,736.9 сая төгрөгийн залруулга хийлээ. Тухайлбал:

- Мал аж ахуй эрдэм шинжилгээний хүрээлэн бараа материалын зардалд бүртгэлтэй 14.4 сая төгрөгийн номыг үндсэн хөрөнгөнд бүртгэн залруулсан;
- Ангаах ухааны хүрээлэн урьдчилж гарсан эрдэм шинжилгээний судалгааны ажлын зардлыг зөрүүтэй тайлагнасан;
- Ургамал хамгаалал эрдэм шинжилгээний хүрээлэн үлдэгдэл төвлөрүүлсэн орлогыг тайланд тусгаагүй 5.1 сая төгрөг, эрдэм шинжилгээний судалгааны ажлын зардлын 335.5 сая төгрөгийн орлого, зарлагыг зөрүүтэй тайлагнасан;

- Ургамал газар тариалангийн хүрээлэн үндсэн хөрөнгийн элэгдлийг 507.6 сая төгрөгөөр дутуу байгуулсан;
- Дулааны техник үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн зээлийн орлогыг буруу ангилсан 12.5 сая төгрөг, бараа материалыг шууд зардлаар бүртгэсэн 7.0 сая, өглөгийг орлогын дансанд бүртгэсэн 38.0 сая, урьдчилж гарсан зардлыг шууд зардлаар бүртгэсэн 326.1 сая төгрөгийг залруулсан;
- Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн нийгмийн даатгалын суутгалын 0.5 сая, Кассын үлдэгдэл 0.1 сая, эрдэм шинжилгээний судалгааны ажлын зардал 42.2 сая, нийт 42.9 сая төгрөгийг тус тус залруулсан байна.

2.9. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

2.9.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 177.6 сая, эцсийн үлдэгдэл 265.4 сая төгрөг болж, 87.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	177.6	265.4	97.1
Дүн	177.6	265.4	97.1

Эх сурвалж: ШУТС-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 265.4 сая төгрөг арилжааны банкны дансанд байршиж байна.

Төрийн санд дансгүй Дулааны техникийн үйлдвэрлэл экологийн хүрээлэн тендер шалгаруулалтын гүйцэтгэж байгаа ажил үйлчилгээний орлого 132.6 сая, Ургамал газар тариалан хүрээлэнгийн харьяа Агроэкологи бизнесийн сургууль оюутны сургалтын төлбөрийн 132.8 сая төгрөгийн үлдэгдэл арилжааны банкны дансанд байршиж байна.

Аудитын илрүүлэлт:

- Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн 1.7 сая, байгууллагад бэлэн мөнгө хандивласан 0.5 сая буюу нийт 2.2 сая төгрөг, Мал эмнэлгийн хүрээлэн үйл ажиллагааны орлогыг харилцах дансанд тушаагаагүй шууд зарцуулсан 8.5 сая төгрөг, Ургамал хамгаалал эрдэм шинжилгээний хүрээлэн бэлэн мөнгөний тайлан гаргаагүй 2.8 сая, нийт 13.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

2.9.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 1,302.2 сая, эцсийн үлдэгдэл 1,101.8 сая төгрөг болж, 200.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	22.4	15.2	-7.2
Төлбөртэй үйлчилгээний авлага	632.1	502.0	-130.1
Татаас, санхүүжилтийн авлага	160.3	164.7	4.4
Зээлийн хүүгийн авлага			
Бусад авлага	487.3	419.8	-67.5
Зээлийн авлага			

Дүн	1,302.2	1,101.8	-200.4
------------	----------------	----------------	---------------

Эх сурвалж: ШУТС-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 530.0 сая төгрөгийн дараах авлага байна. Үүнд:

- Шинжлэх ухаан технологийн сангийн эргэн төлөгдөх нөхцөлтэй зэхэц ажлын авлага 481.5 сая, Татаас санхүүжилтийн авлага 10.6 сая;
- Дулааны техникийн үйлдвэрлэл технологийн хүрээлэнгийн тендерийн баталгааны авлага 117.7 сая;
- Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдлийг татан төвлөрүүлж буцааж авах авлага 141.0 сая;
- Ургамал газар тариалангийн хүрээлэнгийн төмс, улаан буудай борлуулалтын авлага 299.5 сая;
- Уламжлалт ангаах ухаан технологийн хүрээлэн олон улсын арбитрын шүүхийн шийдвэртэй гадаад байгууллагаас авах авлага 38.6 сая;
- Мал аж ахуй эрдэм шинжилгээний хүрээлэнгийн нийгмийн даатгалаас авах авлага, 10.0 сая, олон улсын байгууллагаас хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн авлага 30.6 сая;
- Уул уурхайн хүрээлэнгийн техник эдийн засгийн үндэслэлийн авлага 23.0 сая;

Шинжлэх ухаан, технологийн сангийн харьяа хүрээлэн улсын төсөвт төвлөрүүлсэн нэмэлт санхүүжилтийн дансны 2019 оны жилийн эцсийн үлдэгдлээс буцаан олгохоор тооцоо нийлж авлагаар тусгасан 170.1 сая төгрөг, “Дулааны техникийн үйлдвэрлэл, экологийн хүрээлэнгийн Төрийн банкинд тендерийн баталгаанд тусгаарлан байршуулсан 117.8 сая төгрөгийн авлагын нөлөөллийг тооцож үзвэл цэвэр бууралт 488.0 сая төгрөгөөр тайлагнагдах үр дагавартай байна.

Аудитын илрүүлэлт:

Мал эмнэлгийн хүрээлэн татаас санхүүжилтийн авлага 3.7 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, Ургамал газар тариалангийн хүрээлэнгийн төсвийг зохистой удирдаагүйгээс 147.6 сая төгрөгийн авлага нэмэгдсэн байна.

2.9.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 10,870.9 сая, эцсийн үлдэгдэл 20,004.3 сая төгрөг болж, 9,133.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	10,858.4	19,982.7	9,124.3
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	1.7	2.6	0.9
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	9.6	19.0	9.4
Цалингийн урьдчилгаа			
Томилолтын урьдчилгаа	1.2	0.0	-1.2
Дүн	10,870.9	19,976.0	9,133.4

Эх сурвалж: ШУТС-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэлд өмнөх онуудад үүссэн 21.6 сая төгрөгийн бараа ажил, үйлчилгээний төлбөрүүд байна. Үүнд: Уламжлалт ангаах ухааны хүрээлэн байшин барих зардал 19.0 сая, ШУТС-ийн шатахууны үлдэгдэл 2.6 сая байна.

Урьдчилж төлсөн зардал дансны үлдэгдэл 2019 оны эхэнд 10,858.4 сая төгрөгөөр, оны эцэст 19,982.7 сая төгрөгөөр тайлагнагдсан бөгөөд 2019 онд Шинжлэх ухаан

технологийн сан, харьяа хүрээлэн төвүүдийн шинжлэх ухаан, технологийн төсөлд олгосон санхүүжилтийн дүн 9,133.4 сая төгрөгийн цэвэр өсөлттэй байна.

2.9.4 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 2,241.5 сая, эцсийн үлдэгдэл 2,137.1 сая төгрөг болж, 104.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 4 Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалт материал	550.7	401.6	-149.1
Эм боох материал	36.8	28.5	-8.3
Дуусаагүй үйлдвэрлэл	5.2	9.8	4.6
Бэлэн бүтээгдэхүүн	278.9	280.4	1.5
Бичиг хэрэг материал	127.6	143.6	16.0
Аж ахуйн материал	447.8	516.1	68.3
Сэлбэг хэрэгсэл	77.6	50.1	-27.5
Түлш шатах тослох материал	1.9	2.6	0.7
Барилгын засварын материал	97.0	95.5	-1.5
Хүнсний материал	19.8	12.2	-7.6
Бусад хангамжийн материал	260.3	251.0	-9.3
Мал амьтад	337.9	345.7	7.8
Дүн	2,241.5	2,137.1	-104.4

Эх сурвалж: ШУТС-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үнэт зүйлсийн төрлөөр авч үзвэл, түүхий эд материал 157.3 сая төгрөгөөр буурсан, бэлэн бүтээгдэхүүн 1.6 сая төгрөгөөр, дуусаагүй үйлдвэрлэл 4.5 сая төгрөгөөр, мал амьтад 7.8 сая төгрөгөөр, хангамжийн материал 40.0 сая төгрөгөөр өссөн байна.

Мал эмнэлгийн хүрээлэн түүхийн эд материал 140.0 сая, хангамжийн материал 20.2 сая төгрөгөөр буурсан байна.

Аудитын илрүүлэлт:

Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн 1.4 сая төгрөгийн анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн, Ургамал хамгаалал эрдэм шинжилгээний хүрээлэн бараа материалын үлдэгдэлд хэсэгчилсэн тооллого хийхэд дэлгэрэнгүй бүртгэлээс 42.7 сая төгрөгөөр зөрүүтэй зөрчлүүд илэрсэн.

2.9.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 47,428.1 сая, эцсийн үлдэгдэл 49,936.0 сая төгрөг болж, 2,507.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	23,468.3	25,991.2	2,522.9
Биет бус хөрөнгө	23,959.8	23,944.8	-15.0
Дүн	47,428.1	49,936.0	2,507.9

Эх сурвалж: ШУТС-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мал эмнэлгийн хүрээлэн нь 2018 онд улсын хөрөнгө оруулалтаар бий болсон улсын комиссын актаар хүлээн авсан Конторын барилгыг бүртгэх зөвшөөрөл Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас гараагүй байснаас шалтгаалж барилга дансанд

шилжүүлээгүй 1,900.0 сая төгрөгийн барилгыг 2019 онд бүртгэж авсан, ТӨБЗГ-ын 2019 оны А-1/4173 тоотын дагуу Мал эмнэлгийн хүрээлэнгийн 215.9 сая төгрөгийн автомашин, тоног төхөөрөмж 1,822.2 сая төгрөгөөр бэлтгэсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

Ангаах ухааны хүрээлэн урсгал зардлаас 1.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн, Ургамал газар тариалангийн хүрээлэн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 21.7 сая төгрөгийн хөрөнгийг дахин үнэлээгүй, Ангаах ухааны хүрээлэн 6.2 сая, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн 13.9 сая төгрөгийн ашиглагдаагүй үндсэн хөрөнгөнд элэгдэл байгуулсан, Мал эмнэлгийн хүрээлэн газрын дахин үнэлгээг 26.5 сая төгрөгөөр бууруулж буруу тооцоолсон.

2.9.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 602.2 сая, эцсийн үлдэгдэл 407.2 сая төгрөг болж, 195.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 6 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өссөн+ Буурсан -
Богино хугацаат өр төлбөр дүн	283.4	114.8	-168.6
Өглөг	266.1	114.6	-151.5
Урьдчилж орсон орлого	17.3	0.1	-17.2
Урт хугацаат өр төлбөр дүн	318.8	292.4	-26.4
Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн зээл	203.0	179.1	-23.9
Төслийн зээл	115.8	113.3	-2.5
Нийт дүн	602.2	407.2	-195.0

Эх сурвалж: ШУТС-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 407.2 сая төгрөг, Ургамал газар тариалангийн хүрээлэнгийн 168.5 сая төгрөгийн өр төлбөрийг барагдуулсантай холбоотой өр байна.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 292.4 сая төгрөгөөс: Ургамал газар тариалангийн хүрээлэн нь Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас трактор худалдан авахаар 179.1 сая төгрөгийн зээл авч, авсан зээлээс шалтгаалан үүссэн, Мал аж ахуй эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 113.3 сая төгрөгийн Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас төслийн зээл авснаас шалтгаалан үүссэн өр байна.

Аудитын илрүүлэлт:

Ургамал газар тариалангийн хүрээлэн төсвийг зохистой удирдаагүйгээс 113.2 сая төгрөгийн өр төлбөрийг нэмэгдүүлсэн, Мал эмнэлгийн хүрээлэн 24.7 сая төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлж баталгаажуулаагүй.

2.9.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 61,418.1 сая төгрөг байсан бол 73,037.4 сая төгрөг болж, 11,619.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7 Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт/+, бууралт -/
Засгийн газрын оруулсан капитал	38,325.1	38,305.8	-19.3

Хуримтлагдсан үр дүн	9,094.4	20,738.4	11,644.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	13,998.6	13,993.2	-5.4
Дүн	61,418.1	73,037.4	11,619.3

Эх сурвалж: ШУТС-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мал эмнэлгийн хүрээлэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд барьж ашиглалтад орсон 1,900.0 сая төгрөгийн барилга нэмэгдсэнтэй холбоотой байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 19,224.8 сая төгрөгийн урсгал зардлын төсөв батлагджээ.

Нийт зардлын 18,757.2 сая төгрөгийг улсын төсвөөс, 467.6 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 0.1 сая төгрөг байсан бол улсын төсвөөс 18,757.2 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагаанаас 514.6 сая, туслах үйл ажиллагаанаас 21.1 сая, нийт 19,292.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 19,117.7 сая төгрөгийг зарцуулж, 175.3 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна

Нэмэлт төсөв: Хандив тусламжаар 14 байгууллагаас 1,652.2 сая, дээд шатны төсвийн захирагчаас 192.5 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1,651.1 сая, нийт 3,500.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс Бараа үйлчилгээний зардалд 3,310.0 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 190.0 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Өмнөх онуудаас хэрэгжиж ирсэн 2017 оноос урьдчилж гарсан зардалд хуримтлуулан бүртгэсэн төслүүдээс тайлант хугацаанд 6 төслийн гүйцэтгэл хянагдаж хаагдсан байна. Цаашид төсөл хөтөлбөрийн гүйцэтгэлийг хянах, бүртгэлд нь хяналт тавьж ажиллах талаар дараагийн аудитаар авч үзэх.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Шинжлэх ухаан технологийн сан нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 142 мэдээллийг хугацаанд нь, 9 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Батлагдсан төсөв, хандив тусламж, санхүүгийн тайлан гэх мэт мэдээллүүдийг хуулийн хугацаанд байршуулсан байна.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид нийт 3 зөвлөмж өгснөөс 1 зөвлөмжийг хэрэгжүүлж, 2 зөвлөмж хэрэгжих шатанд, зөвлөмжийн хэрэгжилт 78.3 хувьтай байна.

Он дамжсан урт хугацаат зээл, дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй, бүртгэлээр тавих хяналт сул гэсэн зөвлөмжүүд хэрэгжилт дутуу байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Шинжлэх ухаан технологийн сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Шинжлэх ухаан технологийн сангийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр

хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь шинжлэх ухаан технологийн сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Орлогын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

ШУТС-ийн үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 18.9 сая төгрөгийн батлагдсан боловч орлогыг бүрдүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэснийг мөрдөж ажиллаагүй байна.

3.1.2 Эрсдэл:

Холбогдох хууль журам заавар зөрчигдөх;

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Өөрийн үйл ажиллагааны орлогыг бодитой төлөвлөж, бүрэн төвлөрүүлэх, төсвийн төвлөрүүлэн захирагч хянал тавьж ажиллах;

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.2. Авлага, өглөгийн данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Санхүүгийн тайлангаарх 265.0 сая төгрөгийн авлага, 37.4 сая төгрөгийн өглөгийн тооцоо нийлж баталгаажуулаагүй, барагдуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн

нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах; гэснийг тус тус зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл:

Авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байх, төсөв хэтрэх;

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах, барагдуулах, төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх;

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.3. Зардлын данстай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Тус сангийн 2 албан хаагчид шүүхийн шийдвэрийн дагуу ажилгүй байсан хугацааны цалин 22.4 сая төгрөгийг цалингийн сангаас олгосон байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103.1-д "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэж заасныг зөрчсөн байна.

3.3.2 Эрсдэл:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байх, төсөв хэтрэх;

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Холбогдох эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлэх, буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж зөрчлийг арилгах арга хэмжээ авах;

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.4. Анхан шатны баримттай холбоотой асуудал

3.4.1 Илрүүлэлт:

Анхан шатны баримтын бүрдэл хүчин төгөлдөр бус гарын үсгийн бүрдэлгүй 4.7 сая төгрөгийн баримтаар бүртгэлд тусгасан, тайланг хянаж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 13 дугаар зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна" гэснийг хангаж ажиллаагүй байна.

3.4.2 Эрсдэл:

Бараа материал дутагдах, ашиглан шамшигдал гарах;

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтын бүрдлийг хангах, тайланг баталгаажуулах;

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.5. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

3.5.1 Илрүүлэлт:

Байгууллагуудын онцлогт тохируулан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэх.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэж заасантай нийцэхгүй байна.

3.5.2 Эрсдэл:

Ажил гүйлгээг бүрэн тусгагдахгүй байх;

3.5.3 Өгсөн зөвлөмж:

Байгууллагын онцлогт тохирсон бодлогын баримт бичгийг шинэчлэн мөрдөж ажиллах;

3.5.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.6. Дотоод хяналттай холбоотой асуудал

3.6.1 Илрүүлэлт:

Нийт 13 байгууллага нэгтгэгддэгээс түүвэрт 4, нийт 9 байгууллага санал дүгнэлт гарснаас зөрчилгүй 7, хязгаарлалттай 2 санал дүгнэлттэй алдаа зөрчил, залруулгын дүн өндөр байгаа нь бүртгэлээр тавих хяналт болон дотоод хяналт сул байна.

3.6.2 Эрсдэл:

Алдаа дутагдал гарах, холбогдох хууль журам зөрчигдөх;

3.6.3 Өгсөн зөвлөмж:

Бүртгэлээр тавих хяналт болон дотоод хяналтыг сайжруулах;

3.6.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.7. Бүтэц орон тоо, цалингийн шатлалтай холбоотой асуудал

Байгууллагын бүтэц орон тоо баталсан тушаалуудаар албан хаагчдын цалин тогтоолт ангилал зэрэглэлийг ажилласан жил, шатлалын дагуу тогтоогоогүй байна.

Энэ нь Цалингийн ангилал, зэрэглэл, шатлалыг ажилласан жилээр дүйцүүлэн тогтоох, засгийн газрын 2019 оны 276 дугаар тогтоолын 6-д заасны дагуу тогтоогоогүй зөрчсөн байна.

3.7.2 Эрсдэл:

Алдаа дутагдал гарах, холбогдох хууль журам зөрчигдөх;

3.7.3 Өгсөн зөвлөмж:

Бүртгэлээр тавих хяналт болон дотоод хяналтыг сайжруулах;

3.7.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2020 оны 9 дүгээр сарын 1-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Дансны код	Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	14,592,339.8	23,508,724.2
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	177,661.6	265,411.8
33	АВЛАГА	1,302,178.4	1,101,796.1
34	УРЬДЧИЛГАА	10,870,947.1	20,004,383.0
35	БАРАА МАТЕРИАЛ	2,241,552.7	2,137,133.3
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	47,428,097.0	49,936,003.1
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	47,428,097.0	49,936,003.1
39200	Биет хөрөнгө	23,468,298.5	25,991,166.9
39300	Биет бус хөрөнгө	23,959,798.5	23,944,836.2
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	62,020,436.8	73,444,727.3
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	602,269.1	407,240.6
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	283,441.7	114,828.2
41300	Өглөг	266,138.8	114,675.8
41400	Урьдчилж орсон орлого	17,302.9	152.4
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	318,827.4	292,412.4
42200	Урт хугацаат зээл	318,827.4	292,412.4
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	61,418,167.6	73,037,486.7
51	Засгийн газрын хувь оролцоо	61,418,167.6	73,037,486.7
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	38,325,145.0	38,305,846.9
51200	Хуримтлагдсан үр дүн	9,094,419.3	20,738,394.8
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	13,998,603.3	13,993,245.1
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	62,020,436.8	73,444,727.3

4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Дансны код	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	23,750,257.6	32,329,265.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,960,181.4	8,148,142.3
120	Нийтлэг татварын бус орлого	2,887,471.8	8,032,464.6
122	Тусламжийн орлого	-	115,677.7
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	72,709.6	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	20,790,076.1	24,181,123.4
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	22,441,191.8	20,878,378.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	22,441,191.8	20,878,378.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	22,219,150.1	20,557,674.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7,963,125.4	9,096,294.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	958,547.1	1,146,565.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	689,735.7	783,429.4
2104	Хангамж, бараа материалын зардал	398,462.2	454,124.2
2105	Нормативт зардал	407,336.0	417,204.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	174,623.1	166,398.3
2107	Томилот, зочны зардал	207,948.6	429,811.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,438,041.5	3,732,651.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,981,330.5	4,331,195.0
211	ХҮҮ	12,044.3	5,803.6
212	ТАТААС	2,666.7	1,320.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	207,330.7	313,580.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,309,065.8	11,450,887.4
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	149,778.3	196,008.8
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	124,936.0	40.5
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,333,908.0	11,646,855.7

4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Дансны код	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	23,357,628.7	26,154,828.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,383,590.7	3,428,551.9
120	Нийтлэг татварын бус орлого	2,310,881.1	3,402,614.1
122	Тусламжийн орлого	-	25,937.8
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	72,709.6	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	20,992,038.0	22,726,276.5
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	22,638,410.5	25,628,424.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	22,638,410.5	25,628,424.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	22,257,719.6	25,137,162.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7,913,734.2	9,049,263.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	945,904.2	1,244,187.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	691,540.8	772,116.3
2104	Хангамж, бараа материалын зардал	288,539.1	390,126.2
2105	Норматив зардал	398,740.0	372,719.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	161,569.6	222,431.5
2107	Томилолт, зочны зардал	210,709.9	453,410.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,701,740.3	10,198,647.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	945,241.5	2,434,259.6
211	ХҮҮ	12,044.3	5,803.6
212	ТАТААС	1,644.7	2,342.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	367,001.8	483,116.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	737,218.3	526,403.8
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	545,269.6	398,175.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	545,269.6	398,175.8
2200	Дотоод эх үүсвэрээр	545,269.6	398,175.8
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-545,269.6	-398,175.8
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-162,584.2	-40,477.8
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	162,584.2	40,477.8
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	29,364.5	87,750.2
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	148,297.1	177,661.6
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	177,661.6	265,411.8

4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Дансны код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	24,610,252.1	-	24,610,252.1
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	390,283.1	-	390,283.1
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	25,000,535.2	-	25,000,535.2
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	11,191,309.3	-	11,191,309.3
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	23,892,415.1	-	23,892,415.1
6	Тайлант үеийн үр дүн	1,333,908.0	-	1,333,908.0
7	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	61,418,167.6	-	61,418,167.6
8	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-2,880.2	-	-2,880.2
9	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	61,415,287.4	-	61,415,287.4
10	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-5,358.2	-	-5,358.2
11	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-19,298.2	-	-19,298.2
12	Тайлант үеийн үр дүн	11,646,855.7	-	11,646,855.7
13	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	73,037,486.7	-	73,037,486.7

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	19,224,800.8	19,117,665.5	107,135.2	99.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	19,224,800.8	19,117,665.5	107,135.2	99.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	19,170,701.3	19,063,701.8	106,999.4	99.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,493,145.4	6,474,935.4	18,210.1	99.7
210101	Үндсэн цалин	5,526,188.2	5,981,033.5	(454,845.3)	108.2
210102	Нэмэгдэл	714,802.0	360,300.3	354,501.6	50.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	251,155.4	132,601.5	118,553.8	52.8
210104	Урамшуулал	1,000.0	1,000.0	-	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	967,246.0	898,557.0	68,688.8	92.9
210201	Тэтгэврийн даатгал	721,262.5	805,490.7	(84,228.2)	111.7
210202	Тэтгэмжийн даатгал	61,496.0	23,764.4	37,731.5	38.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	49,196.7	18,494.6	30,702.0	37.6
210204	Ажилгүйдлийн даатгал	12,299.0	4,536.7	7,762.2	36.9
210205	Эрүүл мэндийн даатгал	122,991.8	46,270.5	76,721.2	37.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	521,896.8	513,481.9	8,414.8	98.4
210301	Гэрэл, цахилгаан	170,288.8	222,726.7	(52,437.9)	130.8
210302	Түлш, халаалт	177,480.2	125,299.9	52,180.2	70.6
210303	Цэвэр, бохир ус	45,100.9	35,528.3	9,572.5	78.8
210304	Байрны түрээс	129,026.9	129,926.9	(900.0)	100.7
2104	Хангамж, бараа материалын зардал	79,327.9	76,401.3	2,926.5	96.4
210401	Бичиг хэрэг	8,532.0	13,922.5	(5,390.5)	163.2
210402	Тээвэр, шатахуун	12,071.0	8,582.9	3,488.0	71.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	46,981.1	40,700.2	6,280.8	86.6
210404	Ном, хэвлэл	5,854.9	4,765.5	1,089.3	81.4
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,149.4	1,960.7	(811.3)	170.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,739.5	6,469.3	(1,729.8)	136.5
2105	Норматив зардал	4,727.2	4,713.7	13.5	99.7
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,727.2	4,713.7	13.5	99.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,240.8	10,240.8	-	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,720.8	7,720.8	-	100.0
210604	Урсгал засвар	2,520.0	2,520.0	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	31,932.4	30,467.8	1,464.5	95.4
210702	Дотоод албан томилолт	31,932.4	30,467.8	1,464.5	95.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,055,222.4	11,048,013.9	7,208.4	99.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,017,735.6	11,016,518.1	1,217.4	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	16,460.0	15,560.0	900.0	94.5
210803	Даатгалын үйлчилгээ	493.0	493.0	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,963.4	1,403.3	560.0	71.5
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	270.0	134.0	136.0	49.6

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,964.2	3,964.2	-	100.0
210807	Газрын төлбөр	14,285.8	9,890.7	4,395.0	69.2
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	50.0	50.0	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,962.2	6,889.6	72.5	98.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,462.2	3,353.6	108.5	96.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,500.0	3,536.0	36.0	98.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	54,099.5	53,963.7	135.7	99.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	54,099.5	53,963.7	135.7	99.7
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,499.5	26,499.4	0.0	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	27,600.0	27,464.2	135.7	99.5
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	19,224,800.8	19,117,551.6	107,249.1	99.4
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	18,757,184.7	18,581,828.2	175,356.4	99.1
310001	Улсын төсвөөс санхүүжих	18,757,184.7	18,581,828.2	175,356.4	99.1
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	467,616.1	535,723.3	(68,107.2)	114.6
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	406,115.3	514,627.2	(108,511.9)	126.7
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	61,500.8	21,096.1	40,404.6	34.3
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	114.6	(114.6)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	0.7	(0.7)	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1252	1280	-28	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	12	12	0	
610001	Төсвийн байгууллага	12	12	0	
610002	Төсвөөс гадуур байгууллага	0	0	0	
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	620	634	-14	
620001	Удирдах ажилтан	12	12	0	
620002	Гүйцэтгэх ажилтан	512	525	-13	
620003	Үйлчлэх ажилтан	96	97	-1	
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	620	634	-14	

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	3,500,088.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	3,500,088.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	3,299,842.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	512,937.1
210101	Үндсэн цалин	-	491,631.9
210105	Гэрээт ажлын хөлс	-	21,305.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	54,542.4
210201	Тэтгэврийн даатгал	-	54,542.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	3,772.5
210302	Түлш, халаалт	-	1,432.5
210304	Байрны түрээс	-	2,340.0
2104	Хангамж, бараа материалын зардал	-	221,545.8
210401	Бичиг хэрэг	-	37,106.5
210402	Тээвэр, шатахуун	-	158,043.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	10,200.8
210404	Ном, хэвлэл	-	7,450.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	8,744.5
2105	Норматив зардал	-	22,404.5
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	823.4
210502	Хоол, хүнс	-	20,342.3
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,238.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	205,467.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	85,440.0
210602	Тавилга	-	14,659.7
210604	Урсгал засвар	-	105,367.3
2107	Томилолт, зочны зардал	-	318,562.5
210701	Гадаад албан томилолт	-	42,468.2
210702	Дотоод албан томилолт	-	276,094.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	921,092.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	920,690.2
210807	Газрын төлбөр	-	401.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,039,518.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	12,597.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	1,026,920.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	200,245.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	10,237.6
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	1,013.2
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	9,224.3
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	190,007.6
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	-	190,007.6
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	3,500,088.1
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	3,500,088.1
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	1,618,545.3

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	192,577.4
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,688,965.3
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Аудитын тайлангийн хавсралт

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2019 он	Аудитын нэр:	Санхүүгийн тайлангийн аудит	САГ-2020/22/СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:		ШУТСан		сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /сая төгрөгөөр/	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5
1	Ажилчдын ээлжийн амралтыг олгохдоо унаа хоолны нөхөн олговрыг амралтын дунджаас хасаж тооцоолоогүй 2.6 сая төгрөгийг илүү олгосон байна.	2.6	Төлбөрийн акт тогтоох	Шинжлэх ухаан технологийн сангийн захирал, Нягтлан бодогч	М.Тунгалаг, Б.Намжилсүрэн
Актын дүн		2.6	1		
2	Нийгмийн даатгалын тайлангаар 6.7 сая төгрөгийн илүү төлөлт үүссэн, авлагаар бүртгээгүй байна.	6.7	Албан шаардлага хүргүүлэх	Шинжлэх ухаан технологийн сангийн захирал, Нягтлан бодогч	М.Тунгалаг, Б.Намжилсүрэн
Албан шаардлагын дүн		6.7	1		
3	ШУТС-ийн үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 18.9 сая төгрөгөөр батлагдсан орлогыг огт бүрдүүлээгүй байна.	18.9	Зөвлөмж өгөх	Шинжлэх ухаан технологийн сангийн захирал, Ерөнхий нягтлан бодогч, Нягтлан бодогч	М.Тунгалаг, С.Оюунтунгалаг, Б.Намжилсүрэн
4	Санхүүгийн тайлангаарх 265.0 сая төгрөгийн авлага, 37.4 сая төгрөгийн өглөгийн тооцоо нийлж баталгаажуулаагүй, барагдуулаагүй байна.	302.4	Зөвлөмж өгөх		
5	Тус сангийн 2 албан хаагчид Шүүхийн шийдвэрийн дагуу ажилгүй байсан хугацааны цалин 22.4 сая төгрөгийг цалингийн сангаас олгосон байна.	22.4	Зөвлөмж өгөх		
6	Анхан шатны баримтын бүрдэл хүчин төгөлдөр бус гарын үсгийн бүрдэлгүй баримтаар бүртгэлд тусгасан, тайланг хянаж баталгаажуулаагүй байна.	7.4	Зөвлөмж өгөх		
7	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг байгууллагын онцлогт тохируулан шинэчлэх.	-	Зөвлөмж өгөх		
8	Байгууллагын бүтэц орон тоо баталсан тушаалуудаар албан хаагчдын цалин тогтоолт ангилал зэрэглэлийг ажилласан жил, шатлалын дагуу тогтоогоогүй байна.	-	Зөвлөмж өгөх		
9	Нийт 13 байгууллага нэгтгэгддэгээс түүвэрт 4, зөрчилгүй 7, хязгаарлалттай 2 санал дүгнэлттэй алдаа зөрчил, залруулгын дүн өндөр байгаа нь бүртгэлээр тавих хяналт болон дотоод хяналт сул байна.	-	Зөвлөмж өгөх		
Зөвлөмжийн дүн		351.1	7		
Зөрчлийн дүн		360.4	9		



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2020 оны 03 дугаар сарын 25

№ 01/82

Улаанбаатар хот

САГ- 2020/22/СТА-ТТЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Шинжлэх ухаан технологийн сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажилчдын ээлжийн амралтыг олгохдоо унаа хоолны нөхөн олговрыг амралтын дунджаас хасаж тооцоолоогүй 2,677,882.00 төгрөгийг цалингаас илүү олгосон байна

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.2-т "Ээлжийн амралтын олговрыг ажилтны тухайн ажлын жилийн дундаж цалин хөлсний хэмжээгээр тогтооно"; Төсвийн тухай хуулийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ"; 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторов 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1-д заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Илүү олгосон цалингийн 2,677,882.00 төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлэх, Төв төрийн сан дахь Үндэсний аудитын газрын улсын төсвийн орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх арга хэмжээ авч, актын биелэлтийг 2019 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Шинжлэх ухаан технологийн сангийн захирал М.Тунгалаг, ерөнхий нягтлан бодогч С.Оюунтунгалаг, нягтлан бодогч Б.Намжилсүрэн нарт хариуцуулав.

АКТЫГ

ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР

С.ОТГОНХОРЛОО

ЗӨВШӨӨРСӨН:

ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН
САНГИЙН ЗАХИРАЛ

М.ТУНГАЛАГ

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

С.ОЮУНТУНГАЛАГ

НЯГТЛАН БОДОГЧ

Б.НАМЖИЛСҮРЭН

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10.20\Richie_Kheree\Akt\2020\03255AG7 Docx

001090243



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 25

№ 01/181

Улаанбаатар хот

САГ- 2020/22/СТА-ТТЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Шинжлэх ухаан технологийн сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийгмийн даатгалын тайлангаар 6,701,301.53 төгрөгийн илүү төлөлт үүссэн, авлагаар үүсгэж, бүртгэлд тусгаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн 14 дүгээр зүйлийн 14.4.1-д "аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 18.1.Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэснийг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах акт тавих, зөрчлийг арилгах албан шаардлага өгөх..." Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нийгмийн даатгалын тайлангаарх илүү төлөлтийн холбогдох тооцоог хийх; зөрчлийг арилгах,
2. Албан шаардлагыг биелэлтийг 2020 оны 09 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Шинжлэх ухаан технологийн сангийн захирал М.Тунгалаг, Ерөнхий нягтлан бодогч С.Оюунтунгалаг, нягтлан бологч Б.Намжилсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ:

ӨГСӨН:

САГ-ЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР *Ц.НАРАНЧИМЭГ*

АУДИТОР *С.ОТГОНХОРЛОО*

ЗӨВШӨӨРСӨН:

ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН
САНГИЙН ЗАХИРАЛ

М.ТУНГАЛАГ
ЕРӨНХИЙ НИЯГТЛАН БОДОГЧ
С.ОЮУНТУНГАЛАГ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.